



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 370 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрдэдлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 7.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бат энд Инвест ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ББСБ” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Бат энд Инвест ББСБ” ХХК /Э.Алтанбулаг/-д үүрэг болгосугай.

3. Бат энд Инвест ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН